

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2018 оны
12 дугаар сарын 24 -ны өдрийн 116 дугаар
тогтоолын хавсралт

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Ерөнхий мэдээлэл

Жендэрийн тэгш байдал нь тухайн нийгэмд тодорхой үнэ цэнэ бүхий бүтээгдэхүүн, боломж, нөөц, урамшууллыг эрэгтэй, эмэгтэй хүмүүс тэгш эдлэх эрхтэйг илэрхийлдэг ба тухайн хүнд хүйсийн ялгаварлалгүйгээр эдгээрийг эдлэх бололцоо, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулах боломж нь энэ тэнцүү байх явдал юм.

Жендэрийн тэгш байдлыг хангаснаар аливаа улс орон эдийн засгийн өсөлтөө нэмэгдүүлж, ядуурлыг бууруулж, үр өгөөжтэй сайн засаглалын чадавхыг бэхжүүлдэг бөгөөд жендэрийн тэгш байдлыг хангах гэдэг нь хөгжлийн чухал стратеги юм.

Иймд орон нутгийн онцлог, хэрэгцээнд тулгуурласан төрийн төв, оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлснээр үндэсний болон орон нутгийн хэмжээнд жендэрийн тэгш байдлыг хангаад зогсохгүй аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааг дэмжихэд чухал хувь нэмэр оруулна.

Төв аймаг нь 2017 оны байдлаар нийт 94.4 мянган хүн амтай, хүн амын 48.4 мянга буюу 51.2 хувийг эрэгтэйчүүд, 46.01 мянга буюу 48.7 хувийг эмэгтэйчүүд эзэлж хүйсийн харьцаа 105.1 хувьтай байгаа нь 100 эмэгтэйд 105 эрэгтэй ногдож байна.

Манай аймгийн хувьд 2007 онд эмэгтэй хүний дундаж наслалт 71.69, эрэгтэй хүнийх 65.51 байсан бол 2017 онд эмэгтэй хүний дундаж наслалт 75.98, эрэгтэй хүнийх 70.43 болж дундаж наслалтын зөрүү 4.6 насаар уртассан хэдий ч эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн дундаж наслалтын зөрүү их, эрэгтэйчүүд дунджаар 5,55 насаар эмэгтэйчүүдээс доогуур насалж байна.

Аймгийн эрүүл мэндийн газрын статистик мэдээллээр аймгийн хэмжээнд 2017 онд 577 хүн нас барсны 64.8 хувийг эрэгтэйчүүд, 35.18 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд эрэгтэйчүүдийн нас баралтын 48.8 хувийг зүрх судасны тогтолцооны өвчин, 25.7 хувийг хавдар, 9.8 хувийг осол, гэмтлийн өвчлөл эзэлж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 51.9 хувь нь эрэгтэйчүүд байгаа зэргийг үзэхэд хөвгүүд, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үйлчилгээ авах эрх хангагдах нөхцөл байдалд анхаарах хэрэгцээ, шаардлага байсаар байна.

Түүнчлэн хөдөлмөрийн зах зээлд эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах, түүний дотор нөхөн үржихүйн насны болон бага насны хүүхэдтэй эмэгтэйчүүдийг ажилд авах сонирхолгүй байх, эмэгтэйчүүдийг эрт тэтгэвэрт гаргах үзэгдэл түгээмэл байна. 2017 оны байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн 50.33 хувь нь эрэгтэйчүүд, шинээр ажлын байртай болсон иргэдийн 64.2 хувь мөн эрчүүд байна.

Аймгийн хэмжээнд боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллагсдын 80,5 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байгаа нь хуульд заагдсан 40:60 гэсэн харьцаа бүхий хүйсийн тэнцвэрт байдлыг хангах заалтын хэрэгжилт хангагдахгүй байгааг харуулж байна.

Сургууль, цэцэрлэгт хамрагдалтын хувьд СӨБ-д хамрагдагсдын 50 хувь нь эрэгтэй, ЕБС-ийн бага ангид 52,3 хувь нь эрэгтэй, дунд ангид 52,2 хувь, ахлах ангид 44,3 хувь нь эрэгтэй суралцагч эзэлж байгаа нь хөвгүүдийн сургууль завсардалт буурч, сургууль, цэцэрлэгт хамрагдалтад эрэгтэйчүүдийн эзлэх хувь нэмэгдэж жендэрийн зөрүүтэй байдал буурсан үзүүлэлттэй байна.

2017 оны байдлаар нийт төрийн албан хаагчдын 66 хувийг эмэгтэй, 34 хувийг эрэгтэй ажилтнууд эзэлж байна. Улс төрийн удирдах албан тушаалтны 34,6 хувь, төрийн захиргааны удирдах албан тушаалтны 61 хувийг эрэгтэйчүүд, харин үйлчилгээний салбарын удирдах албан тушаалтны 70,1 хувь, гүйцэтгэх албан тушаалтны 69,2 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоо хангалтгүй байгааг харуулж байна. Түүнчлэн аймгийн хэмжээнд аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд 7 (17%), сумдын ИТХуралд 208 (39,8%) эмэгтэй төлөөлөгч, Аймгийн ЗДТГ-ын хэлтсийн даргын 4 (66,6%) эмэгтэй, сумын засаг дарга 4 (14,8%), сумын ИТХ-ын дарга 6 (22,2%) эмэгтэй байна. Тус аймаг нь нийт 29 984 өрхтэй бөгөөд нийт өрхийн 6,5 хувийг эмэгтэйчүүд толгойлсон өрх эзэлж байна. Мөн аймгийн хэмжээнд 11,9 мянган малчин өрхөд 19,5 мянган малчин мал аж ахуй эрхэлж байна. Үүнээс нийт малчдын 41,3% буюу 8,1 мянга нь эмэгтэй малчид байна. Түүнчлэн малчин өрхүүдийн хувьд

хүүхдүүдийг биеэ даах чадваргүй бага насанд нь сургуульд сургах болсноор хүүхдийн аюулгүй байдал алдагдаж байгаа зэрэг асуудлуудтай холбогдон эрэгтэйчүүд малаа ганцаар маллаж, эмэгтэйчүүд хүүхдүүдийнхээ хүмүүжил, төлөвшил, аюулгүй байдлыг хариуцахын тулд суурин газар амьдарснаар гэр бүл нь хуваагдан амьдарч малчин өрхүүдийн гэр бүлийн харилцаа, эрүүл мэнд зэрэг нь эрсдэлд орж байна. Иймд малчин эрэгтэйчүүдийн эрүүл мэнд, боловсролын асуудлуудад онцгойлон анхаарах хэрэгцээ, шаардлага тулгараад байна.

Дэд хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд аймгийн жендэрийн салбар зөвлөл, хөтөлбөр боловсруулах ажлын хэсгийн гишүүдийн санал, Иргэний нийгмийн байгууллагаар хийлгэсэн нөхцөл байдлын үнэлгээ болон 3 удаагийн бүлгийн ярилцлагын үр дүнг тусгасан болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хэрэгжүүлэх хугацаа

2.1. Хөтөлбөрийн зорилго

Аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлтөөр дэмжин эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, хүйсийн онцлог, хэрэгцээнд нийцсэн хөгжлийн үр шимээс тэгш хүртэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх нь хөтөлбөрийн зорилго юм.

2.2. Хөтөлбөрийн зорилт

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараахь зорилтыг дэвшүүлнэ:

1. Жендэрийн тэгш байдлыг хангах тогтолцоог бэхжүүлж, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
2. Жендэрийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх;
3. Орон нутагт хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх;
4. Жендэрт суурилсан хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх;

2.3. Хөтөлбөрийн хугацаа: Хөтөлбөрийг 2018-2021 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

3.1. Жендэрийн тэгш байдлыг хангах орон нутгийн тогтолцоог бэхжүүлж, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилтын хүрээнд:

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн				Хугацаа	Хариуцах эзэн
			2018	2019	2020	2021		
3.1.1	Орон нутгийн түвшинд жендэрийн суурь статистик мэдээллийн нэгдсэн санг салбар бүрээр бий болгож, бодлого хөтөлбөрийн хэрэгжилтэд ашиглах	Жендэрт суурилсан статистик мэдээний тоо/сумын түвшинд, агентлагийн түвшинд, аймгийн түвшинд/	1	1	1	1	2019-2021	АЗДТГ, Статистик ийн хэлтэс, бусад хэлтэс, агентлаг, СЗДТГ, ТББ
3.1.2	Жендэрийн салбар зөвлөлийн гишүүд болон орон нутгийн холбогдох удирдлага, ажилтан, албан хаагчид, сайн дурынхны жендэрийн талаарх ойлголт, хандлагыг өөрчлөх, манлайллыг бий болгох чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулах, сургалтад	Сургалт, нөлөөлөлийн үйл ажиллагаанд хамрагдсан хүний тоо Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	30\21	100\15	150\15	70\20	2019-2021	АЗДТГ, хэлтэс, агентлаг,

	хамруулж сургагч бэлтгэх							
3.1.3	Бүх шатны Засаг даргын үр дүнгийн гэрээнд Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар гэрээнд тусгах	Үр дүнгийн гэрээнд тусгасан хувь	-	30	35	40	2019-2021	АЗДТГ, хэлтэс, агентлаг,
3.1.4	Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагуудтай жендэрийн тэгш байдлыг хангах хамтын ажиллагааг хөгжүүлэх	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	4	3	3	3	2019-2021	ЖСХ, АЗДТГ, хэлтэс, агентлаг, СЗДТГ
3.1.5	Хэрэгжилтийг хангах ажлыг сум, байгууллага, аж ахуйн нэгжийн түвшинд хөхүүлэн дэмжиж, шилдэг туршлагыг түгээн дэлгэрүүлэх	Сайн туршлагыг түгээсэн нөлөөллийн үйл ажиллагааны тоо	-	1 10	1 15	1 20	2019-2021	ЖСХ, АЗДТГ, хэлтэс, агентлаг, СЗДТГ
3.1.6	Тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэд, малчид хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн сайн дураар нийгмийн даатгалд хамрагдалтын түвшинд жендэрийн эрх тэгш байдлыг хангаж байгаа эсэхэд тандалт судалгаа хийж, судалгааны үр дүнд үндэслэн зөрүүтэй байдлыг арилгах арга хэмжээ авах	Судалгааны тайлан Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ		1 10	1 17	1 27	2019-2021	НДХ, СЗДТГ,
3.1.7	Нийгмийн хамгаалал, хөдөлмөр эрхлэлт, боловсрол, эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагааг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөн хэрэгжүүлэх	Батлагдсан жендэрийн мэдрэмжтэй төлөвлөгөөний тоо		5	5	5	2019-2021	Хэлтэс агентлагууд, СЗДТГ
3.1.8	Бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, тайланг жендерийн мэдрэмжтэйгээр гаргаж хэвших	Тайлагнаж хэвшсэн байгууллагын тоо		15	20	25	2019-2021	Хэлтэс агентлагууд, СЗДТГ

3.2. Жендэрийн талаарх мэдлэг, хандлагыг сайжруулах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг өрнүүлэх зорилтын хүрээнд;

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн				Хугацаа	Хариуцах эзэн
			2018	2019	2020	2021		

3.2.1	Иргэдэд жендэрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах,	Сургалтад хамрагдагчдын тоо		150	200	250	2019-2021	ЖСХ, АЗДТГ, хэлтэс, агентлаг, СЗДТГ
3.2.2	Эрүүл мэнд, нөхөн үржихүй, гэр бүлийн харилцааны талаар ЕБСургуулийн хүүхдүүдэд нас, сэтгэхүйн онцлогт тохируулан сургалт зохион байгуулах	Сургалтын тоо		10	15	20	2019-2021	АЗДТГ, Статистикийн хэлтэс, бусад хэлтэс, агентлаг, СЗДТГ, ТББ
3.2.3	Суурин болон малчин гэр бүлийн онцлогт нийцүүлэн гэр бүлийн үнэ цэнэ, гэр бүлийн харилцааны чиглэлээр /Суманд 2 -оос доошгүй удаа ТББ иргэний нийгмийн оролцооны байгууллага болон төрийн байгууллага хамтран / сургалт, нөлөөллийн арга хэмжээг арга хэмжээ зохион байгуулж, сургалтын модуль нэвтрүүлэх, бусад үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулах	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Хамрагдагчийн тоо	-	10\500	10\600	10\700	2019-2021	ГБХЗХГ, ХААГ СЗДТГ, ТББ
3.2.4	Иргэдийн харилцаа, хандлага, эрүүл амьдралын зан үйлд суралцаж, хорт, буруу зуршлаас урьдчилан сэргийлэх арга ухааныг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгааг тасралтгүй явуулах	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Хамрагдагчийн тоо	-	10\200	10\250	10\300	2019-2021	АЗДТГ, хэлтэс, агентлаг,
3.2.5	Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх өдөр болон Эрэгтэйчүүдийг хүчирхийллийн эсрэг тэмцэхийг уриалсан "Цагаан туузтаны аян"-ыг өрнүүлж, хэвшүүлэх эрэгтэйчүүдийн оролцоог дэмжсэн аян, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Хамрагдагчийн тоо		5\200	5\250	\300	2019-2021	ЖСХ, АЗДТГ, хэлтэс, агентлаг, СЗДТГ, ТББ
3.2.6	Бүх нийтийн жендэрийн мэдлэгийг дээшлүүлэхэд хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр жендэрийн асуудлаар тусгайлсан сурталчилгаа,	Сурталчилгааны тоо		5	5	5	2019-2021	ЖСХ, НҮХМА, орон нутгийн телевизүүд, ТББ

	мэдээллийг нэвтрүүлэх							
3.2.7	Байгууллага, аж ахуйн нэгж бүрийн эцэг эхийн зөвлөлийн ажлыг хүүхдийн хүмүүжил, төлөвшилд чиглүүлж эцэг эхчүүдэд "Хүмүүжлийн эерэг арга" сургалтыг тогтмол зохион байгуулах	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Хамрагдагчийн тоо	340	1\2500	1\3000	1\3500	2019-2021	ЖСХ, АЗДТГ, ГБХЗХГ, хэлтэс, агентлаг, СЗДТГ

3.3 Орон нутагт хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх зорилтын хүрээнд:

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн				Хугацаа	Хариуцах эзэн
			2018	2019	2020	2021		
3.3.1	Нэгдсэн эмнэлэгт өсвөр үе болон эрэгтэйчүүдийн кабинет байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх /өрөө тасалгааны асуудлыг шийдвэрлэх, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах, санхүү, хүний нөөцийн хангалтыг сайжруулах./АНЭ/	Байгуулагдсан кабинет	-	-	1	1	2019-2021	ЭМГ АЗДТГ, Статистикийн хэлтэс, бусад хэлтэс, агентлаг, СЗДТГ, ТББ
3.3.2	Эрэгтэйчүүдийн өвчлөл, нас баралтад нөлөөлж буй хүчин зүйлст тандалт судалгаа /2019 оныг Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих жил болгож аян өрнүүлэх/ хийж, суурин газрын болон малчин эрэгтэйчүүдийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа, тусламж үйлчилгээг үзүүлэх;	Судалгааны тайлан Оролцогчдын тоо		2\150	2\200	2\250	2019-2021	АЗДТГ, хэлтэс, агентлаг,
3.3.3	Ажил олгогч нарт эрэгтэй, эмэгтэй ажилтныг албан тушаал дэвшүүлэх, тэдний мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, мэргэшлийн ур чадварыг ахиулах, цалин хөлсийг нэмэгдүүлэхэд жендэрийн эрх тэгш байдлыг баримтлах талаар зөвлөмж хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавих	Зөвлөмжийг хэрэгжүүлсэн байгууллагын хувиар	-	30	35	40	2019-2021	АЗДТГ, ҮЭХ, АОЭХ, ҮХАҮТ

3.3.4	Төрийн болон төрийн бус байгууллагуудын эмэгтэйчүүдийн манлайллын ур чадварыг хөгжүүлэх арга хэмжээ, сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлэх;	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Оролцогч эмэгтэйчүүдийн тоо		3\50	5\100	8\150	2019-2021	ЖСХ, АЗДТГ, СЗДТГ, Эмэгтэйчүүдийн зөвлөл
3.3.5	Боловсрол, эрүүл мэндийн салбарт ажиллагч эмэгтэйчүүдэд гэр бүлдээ зарцуулах цагийг нэмэгдүүлэх, боломж нөхцөлийг бүрдүүлэх, хүүхэд хөхүүлэх өрөө тохижуулах зэрэг жендэрийн мэдрэмжтэй зохицуулалтыг бий болгох	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ Тохижуулсан өрөөний тоо	-	3\1	4\1	5\1	2019-2021	ЭМГ, БСУГ, Хэлтэс, агентлагууд, СЗДТГ, Эмэгтэйчүүдийн зөвлөл

3.4. Жендэрт суурилсан хүчирхийлэл болон ялгаварлан гадуурхалттай тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд:

№	Үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин, үр дүн				Хугацаа	Хариуцах эзэн
			2018	2019	2020	2021		
3.4.1	Гэр бүлийн болон эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хандлага өөрчлөх сургалтуудыг зохион байгуулах, хүчирхийллийн хохирогчид нөхөн сэргээх, хамгааллын үйлчилгээ үзүүлэх	Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо Оролцогч эмэгтэйчүүдийн тоо	1	5\200	5\250	5\300	2019-2021	ЖСХ, АЗДТГ, ГБХЗХГ, ХЭҮК, ХЭҮХ, ЦГ СЗДТГ, Эрэгтэйчүүдийн холбоо, Эмэгтэйчүүдийн зөвлөл
3.4.2	Хүчирхийлэлд өртсөн хохирогчийг хамгаалах нэгж (Нэг цэгийн үйлчилгээний төв, Хамгаалах байр зэрэг)-ийн үйл ажиллагааг идэвхжүүлж, үйл ажиллагааг тогтмолжуулах асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх /хамгаалах байранд сэтгэл зүйч ажиллуулах, жилийн үйл ажиллагааны зардлыг шийдвэрлэх	Үйл ажиллагаа нь тогтмолжсон байрны тоо Үйлчлүүлсэн хүний тоогоор		1	1	1	2019-2021	ЖСХ, АЗДТГ, ГБХЗХГ, ХЭҮК, ХЭҮХ, ЦГ СЗДТГ,
3.4.3	Охид, эмэгтэйчүүдийг хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттайгаар төлөвлөн хэрэгжүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг дэмжих	Сургалт, нөлөөллийн ажлын тоо Оролцогчдын тоо	-	5\150	8\200	10\250	2019-2021	ГБХЗХГ, ХЭҮК, ХЭҮХ, ЦГ СЗДТГ, Эрэгтэйчүүдийн холбоо, Эмэгтэйчүүдийн зөвлөл

	мэндийн тасаг, кабинет/АНЭ/							
9	Гэр бүл төлөвлөлт, НҮЭМ-ийн тусламж үйлчилгээнд хамрагдсан эмэгтэйчүүдийн тоо	тоо	-	3500	4000	4500	5000	ЭМГ, ГБХЗХГ, ЖСХ, АЗДТГ
10	Жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэндийн сургалт, сурталчилгааны тоо, хамрагдсан хүний тоо	тоо	-	5/600	6\700	7\800	8\1000	ЭМГ, ЖСХ, АЗДТГ
11	Үйл ажиллагаа нь тогтмолжсон хамгаалах байрны тоо /орон тоо, үйл ажиллагааны зардал шийдвэрлэсэн байдал/	тоо	-	1	1	1	1	ЦГ, ХЭҮТ, ГБХЗХГ ЖСХ, АЗДТГ, ТББ

Тав. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

5.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Жендэрийн салбар хороо удирдлагаар хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж, салбар хооронд уялдуулан зохицуулна.

5.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны хэрэгжилтийг Аймгийн Засаг даргын тамгын газар, Нийгмийн бодлогын хэлтэс хариуцна.

5.3. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, түүний тэргүүлэгчид дэд хөтөлбөрийн төсвийг батална.

5.4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг холбогдох байгууллагууд жил бүрийн төсөвтөө суулгана.

5.5. Аж ахуйн нэгж, байгууллага нь нийгмийн хариуцлагын хүрээнд хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцож санхүүгийн дэмжлэг үзүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилтийн эх үүсвэр, шаардагдах хөрөнгийн хэмжээ

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараахь эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

6.1.1. **Улсын болон орон нутгийн төсвөөс уг хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд жил бүр 3 сая төгрөгийг төсөвлөн зарцуулна.**

6.1.2. олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж болон төсөл, хөтөлбөрийн санхүүжилт; /Мерит төсөл болон ДЗОУБ –тай хамтран ажиллах/

6.1.3. төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив, тусламж;

6.1.4. бусад эх үүсвэр.

Долоо. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ

7.1. Аймгийн Засаг даргын сумдын Засаг дарга нар болон байгууллагын дарга нартай байгуулах үр дүнгийн гэрээнд жендэрийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх заалтыг тусган, хэрэгжилтийг үнэлнэ.

7.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, гүйцэтгэлийн хяналт- шинжилгээ, үнэлгээг жилд нэг удаа аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэстэй хамтран хийж, хэрэгжилтийг аймгийн Иргэдийн Тэргүүлэгчдийн хурлаар танилцуулан, Жендэрийн үндэсний хороонд хүргүүлнэ.

7.3. Хөтөлбөрийн үр дүнгийн хөндлөнгийн үнэлгээг хөтөлбөр хэрэгжих сүүлийн жилд нэг удаа орон нутгийн ТББ-ын төлөөллөөр хийлгэж, үнэлгээний үр дүнг аймгийн Жендэрийн салбар хорооны хуралд танилцуулна.

7.4. Хөтөлбөрийн тайлан, үнэлгээг Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс албан ёсны цахим хуудас болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

7.5. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээг шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.